

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргүүдийн дотроос хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч гэмт хэргийн гаралт жилээс жилд нэмэгдэж, дээрх гэмт үйлдлийн улмаас хохирсон иргэдийн тоо өсч, гэмт хэрэг үйлдэж буй арга, хэлбэр нь улам бүр нарийсч байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь ихэвчлэн буурай хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын орлого багатай, боловсролын түвшин доогуур, эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүд байдаг ба энэ нь тухайн орны эдийн засгийн хөгжил, иргэдийн эрх зүйн мэдлэг тааруу, хуулийн хяналт сул зэрэг нь гол хүчин зүйл болж байдаг байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь ашиг орлогын хувьд мансууруулах бодис, зэвсгийн наймааны дараа орж байна. Энэ гэмт хэрэг нь нэг талаас улс үндэстэн дамнасан, нөгөө талаас нууцаар зохион байгуулагддаг тул түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх чиглэлээр улс орнууд олон улсын түвшинд хамтарч ажиллах шаардлагатай байдаг.

Монгол Улсын иргэд 1990-д оноос гадаадад чөлөөтэй зорчиж, сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхэмлэх, аялах жуулчлах боломжууд ихээр нэмэгдсэн. Үүний зэрэгцээгээр иргэдийн өөр улсад ажиллах, сурах, амьдралаа дээшлүүлэх гэсэн иргэдийн хүсэл, шаардлага хэрэгцээг гэмт этгээдүүд ашиглан жуулчлах, виз гаргаж өгөх, ажилд оруулж өгөх, гадаадын иргэдтэй гэр бүл болоход нь туслах нэрийн дор тэднийг ялангуяа эмэгтэйчүүдийг худалдаалж, ашиг олох хэрэгсэл болгох явдал өсөх хандлагатай байна.

Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэг хуулийн байгууллагад бүртгэгдэн шалгадаг байгаа талаар сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл (2010-2016 он) хүн худалдаалах /ЭХ-ийн 113 дугаар зүйл/ 49 хохирогчтой, 44 гэмт хэрэг, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах /ЭХ-ийн 124 дүгээр зүйл/ 49 хохирогчтой, 89 гэмт хэрэг тус тус цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдсан байна. Гэвч хүн худалдаалах гэмт хэрэг нь нуугдмал далд үйлдэгддэг учир гэмт хэргийн статистик тоо баримт бодит бус, мөн хуулийн байгууллагаар шийдэрлэгдэж байгаа хэрэг цөөн байгааг дурдах нь зүйтэй юм.

Монгол Улс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх уг гэмт хэрэг гарах шалтгаан нөхцлийг тогтоох, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, эрхийг нь хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан хууль тогтоомжуудыг батлан, Олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орсон.

Тухайлбал 2005 онд Монгол Улсын Засгийн газар “Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” Үндэсний хөтөлбөрийг 2006-2014 оны хүртэл 9 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр батлан гаргасан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх, ялангуяа олон улсын түвшинд хэм хэмжээ тогтоосон Конвенц, Протоколд нэгдэх,

тунхаглалыг хүлээн зөвшөөрөх, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, хөтөлбөрийн хэрэгжилтэд зориулан төсөвт хөрөнгө төлөвлөх, энэ чиглэлээр ажилладаг төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, иргэдэд зөв ойлголт төлөвшүүлэх зэрэг асуудлаар ихээхэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2015 онд хөтөлбөр хэрэгжиж дууссан.

Түүнчлэн 2012 онд Улсын Их Хурлаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг батлан гаргасан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн чухал алхам болсон юм. Гэвч дээр дурдсанчлан хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдаж, Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хуулийг баталсан хэдий ч гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл буурахгүй байна. Хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай бүтэц, төсөв байхгүй, бусад хуулиудтай уялдаа холбоо муу байгаагаас гадна хүн худалдаалахаас хэрхэн сэргийлэх, түүнийг таслан зогсооход ямар байгууллага ямар арга хэмжээ авах талаар процедурын хувьд учир дутагдалтай байгаагаас хууль хэрэгжихэд зарим талаар хүндрэлтэй байна.

Эдгээр нөхцөл байдлууд болон Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.1.1-д заасныг хэрэгжүүлэхэд Засгийн газраас “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” Үндэсний хөтөлбөрийг баталж мөрдүүлэх шаардлага гарч байна. Хөтөлбөрийг 2016-2021 он хүртэл 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэх ажил, хариуцах байгууллага, зарцуулах хөрөнгийн төсвийг хамтад нь боловсруулав. Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо олон улсын хэмжээнд хэрэглэж буй 4P paradigm буюу урьдчилан сэргийлэх, хамгаалах, мөрдөн шалгах, хамтын ажиллагаа гэсэн 4 үндсэн чиглэлийг удирдлага болгов.

Энэхүү хөтөлбөрийг Засгийн газраас хэрэгжүүлснээр өмнөх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалахаас арга хэмжээнүүд үргэлжлэхээс гадна бусад хөдөлмөрийн мөлжлөг буюу албадан хөдөлмөрлүүлэх, хүүхэд үрчлэлт, хүний цус эд эрхтний наймаа гэсэн хүн худалдаалахын бусад төрлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хохирогчдыг хамгаалахад дэмжлэг болох юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг төлөвшүүлж, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг дэвшүүлж байна.

3.1.1. хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

3.1.2. хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн болон хохирсон иргэдийг хамгаалах, эрүүл мэндийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

3.1.3. хүн худалдаалах гэмт хэргийн хэлбэр бүрт тохирсон таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

3.1.4. хүүхдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

3.1.5.хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэгч байгууллагууд болон гадаад улс, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн зарчим

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан зарчмыг баримтална.

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлуудын чиглэл

5.1.“Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэсэн **Зорилт 1-ийн** хүрээнд;

5.1.1.Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал /шалтгаан, үйлдэгдэж буй арга зам, сувгууд, нутуг дэвсгэр, хохирогч болон холбогдогчийн мэдээллийн нэгдсэн бүртгэл/-ын судалгааг хийж, энэ төрлийн гэмт хэргийн мэдээллийн санг үүсгэнэ;

5.1.2.Судалгаан дээр үндэслэн хүн худалдаалах гэмт хэргийн талаарх сургалт, сурталчилгааны агуулга, хэлбэрийг тодорхойлно;

5.1.3.Хэрэгцээт сургалтын материалыг боловсруулах, сургалт явуулах, сурталчилгааны агуулга, арга хэлбэрийг тодорхойлох багуудыг сонгоно, сургана;

5.1.4.Хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалтын материал бэлтгэнэ, сургалт явуулна;

5.1.5.Хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгааны агуулга, арга хэлбэрийг батлана, түгээнэ;

5.1.6.Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдэд тогтмол мониторинг хийж, үнэлгээ өгнө;

5.1.7.Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийнэ;

5.1.8.Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэх дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ:

5.1.8.1.хүүхдэд зориулсан контент/хүүхдэд зориулсан анимац, хүүхэлдэй кино, хүүхдийн нэвтрүүлэг, интернэт хэлэлцүүлэг, зураг, сэрэмжлүүлэг, онлайнаар унших болон сонсох хичээл, онлайн зөвлөмж гэх мэт зурган, текстэн, медиа бүтээлүүд/-ийг бэлтгэх, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэт орчинд, хүүхэд залуус ихээр үйлчлүүлдэг сургууль, кино театр зэрэг олон нийтийн газруудаар түгээнэ;

5.1.8.2.хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, энэ төрлийн гэмт хэргийн сэжиг илэрвэл хаана хандах, ямар арга хэмжээ авах зэрэг урьдчилан сэргийлэх шаардлагатай сургалт, сурталчилгааг тогтмол явуулах. Оюутан сурагчдын сургалтын программд энэ төрлийн гэмт хэргийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хичээл оруулах арга хэмжээ авч, сургалтын хөтөлбөр, ном, сургалтын гарын авлага бэлтгэнэ;

5.1.8.3.хүүхэд залууст энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хэлэлцүүлэг, яриа тогтмол хийж байх сургагч багш нарыг сургууль болон хүүхдийн асрамжийн төвүүдийн дотоодод бэлтгэх, эдгээр багш нарыг тогтмол сургах, мэдээллээр хангах онлайн тогтолцоог бүрдүүлнэ;

5.1.8.4.Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сайн дурын хөдөлгөөн өрнүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор нөлөө, аюулын талаарх эрдмийн хурал

зохион байгуулах, илтгэл, эссэ бичлэгийн уралдаан зарлах, лекц унших, хүн худалдаалах гэмт хэргээс ангид байх тайван жагсаал хийх, уриалга гаргах зэргээр олон төрлийн үйл ажиллагаанд оюутан залуусыг идэвхтэй оролцуулах үйл ажиллагааг дэмжин явуулна;

5.1.8.5.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэдтэй ажилладаг сургуулийн багш, нийгмийн ажилтан, асрамжийн газрын ажилтнууд, хүүхдэд зориулсан сургалт дамжаа хичээллүүлдэг сургалтын байгууллага, ТББ-уудын ажилтнуудыг энэ төрлийн гэмт хэргийн ойлголт, урьдчилан сэргийлэх талаарх сургалтад хамруулна;

5.1.8.6.Аж ахуйн нэгжүүдийг энэ төрлийн контентуудыг түгээхэд туслалцаа үзүүлэх замаар нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх талаар уриалга гаргах, хувийн хэвшлийнхнийг энэ үйл ажиллагаанд татан оролцуулах арга хэмжээ зохион байгуулна.

5.2."Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн болон өртөх эрсдэл өндөртэй иргэдийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ." гэсэн **Зорилт 2-ын**:

5.2.1.Хохирогчийг хамгаалах байрыг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

- Хамгаалах байрны дотоод журмыг стандартад нийцүүлэн шинэчлэх;
- хамгаалах байрыг стандарт нийцүүлэн үйл ажиллагааг нь тогтмолжуулах;
- ажиллах хүчнийг сургах;
- төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.

5.2.2.хохирогчдод үзүүлэх халамж, үйлчилгээг стандартын дагуу хийх ажлыг тогтмолжуулна. Халамж, үйлчилгээнд:

- хууль зүйн туслалцаа;
- сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа;
- эмнэлгийн тусламж, үйлчилгээ;
- гадаадад байгаа хохирогч болсон иргэдэд туслах үйлчилгээ;
- хамгаалалтын арга хэмжээ зэрэг хамаарна.

5.2.3.Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн болон өртөх эрсдэл бүхий иргэдийг хамгаалах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулна;
- Эрсдэлд өртөж болзошгүй иргэдийн судалгааг гаргах, тэдэнд сургалт явуулна.

5.2.4.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийг хамгаалах арга хэмжээ авна.

-Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж байгаа болон тэр дундаа хөдөлмөрийн мөлжлөг/мал маллах, морь унах, айлын хүүхэд харах, гуйлга гуйх гэх мэт/-т өртөж байгаа хүүхдийн талаарх мэдээлэл өгөх ТББ, олон нийтийг дэмжих, мэдээлэл авах тогтолцоог бүрдүүлнэ;

-Хууль тогтоомжид энэ төрлийн гэмт хэрэгт хүүхдийг татан оруулахгүй байх, хүүхдийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг тусгах замаар өөрчлөн шинэчлэх, шаардлагатай хууль тогтоомжийг боловсруулна;

-Нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөрүүдийг боловсруулахад “энэ төрлийн гэмт хэрэгт өртөх болон өртсөн хүүхдийг хамгаалах, туслах мэдрэмжтэй байх” шалгуурыг тавьдаг болох хэм хэмжээ, жишигийг тогтооно;

-Энэ төрлийн гэмт хэрэгт хохирсон хүүхдүүдийг хамгаалалтад авч шаардлагатай тохиолдолд асрамж халамжийн төвд хүргэх, тэднийг сэтгэл зүйн болон эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулна;

-Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөх сэтгэл зүйч, хуульчид, багш нарыг мэргэшүүлэх, чадавхжуулна.

5.3.Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;” гэсэн **Зорилт 3-ын** хүрээнд:

5.3.1.“бэлгийн мөлжлөг” хэлбэрээр зорилтот бүлгүүд, алслагдсан дүүрэг, орон нутаг, сургууль завсардсан, эмзэг бүлгийн хүүхэд, биеэ үнэлэгчдэд чиглэсэн ажлыг явуулна;

5.3.2.“хөдөлмөрийн мөлжлөг”-ийн хэлбэрээр Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд хийгдэх хяналт шалгалтыг сайжруулна;

5.3.3.“эд эрхтний наймаа” хэлбэрээр хилийн болон эмнэлгийн байгууллагын хяналтыг сайжруулж, холбогдох байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулна;

5.3.4.“хүүхэд үрчлэлт”-ийн хэлбэрээр гэр бүлийн болон гадаадад зорчих, хил нэвтрэхтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг хангаж, гадаад, дотоод үрчлэлтийн хяналтыг сайжруулна;

5.3.5.НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол улсад хүн худалдаалахтай тэмцэх талаар ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.

5.4.“Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагууд болон гадаад улс, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.” гэсэн **зорилт 5-ын** хүрээнд:

5.4.1.хуулийн хэрэгжилтийг хангахад оролцогч байгууллагууд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор хуулийн хэрэгжилтэд мониторинг хийнэ;

5.4.2.хуулийн хэрэгжилтийг хангах байгууллага, мэргэжилтнүүдэд мэдлэг олгох, ойлголтыг нэг болгох, тэднийг мэргэшүүлэхэд чиглэгдсэн сургалтыг явуулах, цаашид тогтмол явуулах тогтолцоог бүрдүүлнэ;

5.4.3.хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, нөхцөл байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлж урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглана;

5.4.4.хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, стандарт, байгууллагын харилцаа холбооны арга хэрэгслийг бий болгож, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлнэ;

5.4.5.хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улс болон орон нутгийн төсөвт тусгуулах арга хэмжээ авна;

5.4.6.хүн худалдаалахтай тэмцэх хуулийг хэрэгжүүлж байгаа байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд улсын хэмжээнд хяналт, шалгалт хийж холбогдох арга хэмжээг авна;

5.4.7.хуульд хийсэн мониторингийн дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ;

5.4.8.Монгол иргэд ихээр зорчдог, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл бүхий улс орнуудтай хамтын ажиллагааг бий болгон өргөжүүлнэ;

Зургаа. Санхүүжилт.хугацаа

6.1.Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1.улс, орон нутгийн төсөв;

6.1.2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1-д заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал;

6.1.3.гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж;

6.1.4.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хандив, хөрөнгө;

6.1.5.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

6.2.Хөтөлбөрийг 2016-2021 он хүртэл 5 жилийн хугацаагаар хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх үйл ажиллагааг Хууль зүй, дотоод хэргийн яам , Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл /цаашид Дэд зөвлөл гэх/ зохион байгуулна.

7.2.Орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах.хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах арга хэмжээг бүх шатны Засаг дарга хууль сахиулах байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

Найм. Хүрэх үр дүн

8.1.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах байгууллага, албан тушаалтны хариуцлага нэмэгдэж, байгууллага хоорондын уялдаа холбоо, хяналт сайжирна.

8.2.Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар сайжирч, энэ төрлийн гэмт хэргийн гаралт багасна.

8.3.Хүн худалдаалах гэмт хэргийн хэлбэр бүрт тохирсон урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Монгол Улсад бүртгэгдээгүй хүн худалдаалах гэмт хэрэгтэй /эрхтний наймаа, хууль бус хүүхэд үрчлэлт/ тэмцэх нөхцөл бүрдэнэ.

8.4.Хүн худалдаалах гэмт хэргийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцсэн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

8.5.Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаарх олон нийтийн мэдлэг, хандлага дээшилсэн байна.

8.6.Хүн худалдаалахын эсрэг хамтран ажиллах гадаад улс болон Олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжинө.